

**ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАН**
/2021 оны I улирал/

2021 оны 04 дүгээр
сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

Улсын бүртгэлийн байгууллагын өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн үйл ажиллагаа холбогдох хууль, журмын дагуу явагдаж байгаа эсэхийг шалгаж, ажлын үр дүнг тооцох, цаашид анхаарах асуудлаа тодорхойлж, үйл ажиллагааг сайжруулах зорилгоор өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хяналт-шинжилгээ хийж гүйцэтгэв.


Өргөдөл, гомдлыг хүлээн авах хэлбэр:

Иргэн, хуулийн этгээдээс өргөдөл, гомдлыг Засгийн газрын <https://zasag.mn> цахим хуудасны 11-11 мэдээллийн төв, байгууллагын <http://burtgel.gov.mn/> цахим хуудасны “Зочны дэвтэр”, фэйсбүүк хаяг, бүртгэлийн нэгдсэн лавлах утас 1800-1890, бичгээр гэх мэтчилэн бүх хэлбэрээр хүлээн авч байна.

Хүлээн авсан өргөдөл, гомдол:

Тайлант хугацаанд Улсын бүртгэлийн байгууллага нийт 892 өргөдөл, гомдол хүлээн авсан байна. Хүснэгтээр харуулбал:

Д/д	Өргөдөл гомдол хүлээн авсан хэлбэр	Тоо	Харъяалал		Эзлэх хувь
1	Засгийн газрын 11-11 мэдээллийн төв	12	УБЕГ	-	0.13
			НУБГ	12	
			21 аймаг	-	
2	Байгууллагын цахим хуудасны “Зочны дэвтэр”	3	УБЕГ	-	0.03
			НУБГ	3	
			21 аймаг	-	
3	Биечлэн уулзсан	8	УБЕГ	2	0.09
			НУБГ	-	
			21 аймаг	6	
4	Бүртгэлийн нэгдсэн лавлах 1800-1890	26	УБЕГ	-	0.29
			НУБГ	26	
			21 аймаг	-	
5	Бичгээр	843	УБЕГ	289	94.5
			НУБГ	20	
			21 аймаг	534	
Нийт		892			100.0




Нийт өргөдөл, гомдлын 67.16 хувийг өргөдөл, 29.7 хувийг санал, 2.69 хувийг гомдол, 0.34 хувийг хүсэлт, 0.11 хувийг талархал тус тус эзэлж байна.

Ирүүлсэн өргөдөл, гомдлын агуулгын хувьд зонхилж байгаа асуудлаар ангилан авч үзвэл:

№	Зонхилж байгаа асуудал	Өргөдлийн тоо	Эзлэх хувь
1	Иргэний бүртгэлийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар хандсан /төрөлт, нас баралт, нөхөн бүртгэл, лавлагаа, хуулбар, гэрчилгээ, гадаад паспорт авах, гэр бүлийн бүртгэл, цахим үнэмлэх, шилжих хөдөлгөөн, ТҮЦ/	216	24.2
2	Эд хөрөнгийн эрхийн бүртгэлтэй үндсэн үйл ажиллагаа	57	6.4
3	Хуулийн этгээдийн эрхийн бүртгэлтэй үндсэн үйл ажиллагаа	46	5.2
4	Бүртгэл хяналтын үндсэн үйл ажиллагаа /зөрчил арилгуулах, хүчингүй болгох, шалгуулах, хориг цуцлах, залруулга, дүгнэлт гэх мэт/	247	27.7
5	Улсын бүртгэлийн нэгдсэн архив	50	5.6
6	Хүний нөөц, ёс зүй	175	19.6
7	Бусад	101	11.3
Нийт		892	100.0


Бүртгэлийн хяналтын үйл ажиллагаа болон иргэний улсын бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар хандсан өргөдөл, гомдол нийт өргөдөл, гомдлын дийлэнх буюу 51.9 хувийг эзэлж байна.

Бичгээр ирүүлсэн 843 өргөдөл, гомдлыг гаргасан нэгж, агуулгаар нь харуулбал:




Бичгээр хүлээн авсан өргөдөл гомдлын 63.3 хувь нь аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэст, 34.3 хувь нь Улсын бүртгэлийн ерөнхий газарт, 2.4 хувь нь Нийслэл дэх Улсын бүртгэлийн газарт ирсэн байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газарт бичгээр ирсэн өргөдөл гомдлыг холбогдох газраар нь харуулбал:



Улсын бүртгэлийн ерөнхий газарт бичгээр ирүүлсэн 289 өргөдөл, гомдлын 39.2 хувь нь Тамгын газарт, 23.8 хувь нь Хяналт шалгалтын газарт, 12.8 хувь нь Иргэний улсын бүртгэлийн ерөнхий газарт, үлдсэн хувь нь бусад газарт ирүүлсэн байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулан харвал:




Өмнөх оны мөн үеэс тайлант онд 6.5 дахин бага өргөдөл, гомдол ирсэн байна.

Шийдвэрлэлт:

Улсын бүртгэлийн байгууллагад энэ оны нэгдүгээр улиралд ирүүлсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн байдал 84.3 хувь байна.

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дүнг өмнөх онтой харьцуулвал:



Шийдвэрлээгүй 8 өргөдөл, гомдол нь хугацаа болоогүй, хяналтад авсан байна.

БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР